

ЗАХИРЛЫН МЭДЭЭЛЭЛ

Сайн Байцгаана уу,

Та бүхэн манай дунд сургуулийн Хаврын тоглолтыг үзэж сонирхсон уу? Энэ тоглолт үнэхээр сайхан тоглолт болсон. Манай сурагчид сайн жүжиглэж дүрийнхээ дотоод сэтгэлийн хөдөлгөөнийг маш гайхамшигтай чадварлаг илэрхийлж байсан.

ОУДС-ийн хувьд Хаврын улиралд хичээлээс гадуурх аялалууд, жүжигчилсэн тоглолт, шалгалт шүүлэг, төгсөлт гээд олон арга хэмжээ зохиогддог. Та бүхэн манай хуанлид анхаарлаа хандуулаарай.

Манай төгсөлт 5 сарын 28-нд болно. 12-р ангийн сурагчид маань улсын шалгалтуудаа өгч байна. Та бүхэн ирэх хичээлийн жилийн элсэлтийн бүртгэлийн хуудсуудыг бидэнд бөглөж ирүүлээрэй. Сургуульдаа буцаж ирж суралцах хүүхдүүдийнхээ орон тоог баталгаажуулахыг бид хүсэж байна.

Хятад Монголын Олон Улсын Дунд Сургуулиудын Холбооны Удирдах Зөвлөлийн хурал энэ долоо хоногт ОУДС дээр болж байна. Тус Холбооны Удирдах Зөвлөлийн гишүүнээр би өнгөрсөн 3 сард сонгогдсон. Сурагчдад үр ашгаа өгөх олон талын тэмцээн уралдаан, спорт урлагийн арга хэмжээ, багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтын талаар бид энэ хурлын үеэр хэлэлцэж байна.

Та бүхэн манай вэб сайтаар зочлоорой. Бид сайтан дахь зурагнуудаа шинэчилж эцэг эхчүүдэд хэрэгтэй мэдээлэл түлхүү оруулах тал дээр анхаарч ажиллаж байна. Хүссэн цагтаа манай сайтын линк рүү орж хүүхдийнхээ сурлага, даалгаварын талаарх мэдээллийг авах боломжийг бид та бүхэнд удахгүй бүрдүүлж өгөх болно. Ингэснээр эцэг эх, багш нарын хоорондын харилцаа, уялдаа холбоо улам сайжрах болно.

Та бүхнийг хүндэтгэсэн,

Захирал Greg Rayl

Хуанлид тэмдэглэх өдрүүд:

5-р сарын 13	3,4-р ангийг ханд САМР-н талаарх мэдээлэл өгөх өдөр 3-4 цагт
5-р сарын 18	PTG-н уулзалт. Номын санд орой 7 цагт
5-р сарын 21	“Creative Arts” үдэш

2010-2011 оны хичээлийн жилийн элсэлтийн талаар:

Ирэх хичээлийн жилийн элсэлтийн хуудсыг бөглөж бидэнд ирүүлсэнд баярлалаа. Ирэх хичээлийн жилд сургуульдаа эргэж ирж суралцана гэдгээ мэдэгдсэн сурагчдын эцэг эхчүүд Бүртгэлийн болон Төлбөрийн мэдээллийн хуудсыг хүлээн авах болно. Та бүхэн эдгээр хуудсуудыг бөглөж 5 сарын 14-ний дотор бидэнд ирүүлнэ үү. Бид энэ хуудсуудыг авмагч та бүхэнд Бүртгэлийн хураамжаа төлөх төлбөрийн даалгаврыг явуулах болно.

Одоог хүртэл тодорхой биш байна уу? Та бүхэн бидэнд 5 сарын 14-ны дотор хүүхдээ ОУДС-д сургах эсэхээ мэдэгдэх хэрэгтэй. 5 сарын 14-с хойш шинээр ОУДС-д ирж суралцах гэж байгаа сурагчдад элсэлт нээлттэй болно.

БАГА СУРГУУЛИЙН МЭДЭЭ

Хаврын улирал эхэлж бид завсарлагааны цагаараа гадаа агаарт тогтмол тоглож байна. Хичээлийн жилийн сүүлчийн улиралд бид төрөл бүрийн үйл ажиллагаа, явган аялал, зугаалга зохиож байгаатай учир сурагчид сайн хоол идэж, их ус ууж, орой эртхэн унтаж сайн амарч байх хэрэгтэй.

5-р ангийнхан Үзэсгэлэндээ бэлдээд завгүй байгаа бөгөөд энэхүү үйл ажиллагааг сурагчдад ач холбогдолтой болгохын төлөө чармайн ажиллаж байгаа Ms. Faber, Ms. Carroll болон зөвлөгч багш нарт би хувийн зүгээс талархал илэрхийлж байна.

3-5-р ангийн сурагчид 6 сард хоногоор кемп аялалд явах учраас үүнтэй холбоотой мэдээлэлүүдийг дараа долоо хоногт бид та бүхэнд явуулна.

5-р ангийн сурагч Ононбатын Танхилууны аялалын талаарх эрэгцүүлэл:

“5-р ангийн сурагчид 4-р сарын 29-ний өдөр Монголын Уран Зургийн Музей руу аялалаар явлаа. Бид цэгэн аргаар зургийг хэрхэн зурж болох талаар сурахаар Ms. Carroll, Ms. Selenge, Ms. Eret, болон Ms. Denzee нартай хамт явсан. Гэхдээ бид аялалаар явахаас өмнө зургийнхаа хичээл дээр энэ аргаар зурагдсан 3 зургийг судалсан. Бид эдгээр зургийг судалж байхдаа зургийн талаар юу мэдэрч байгаагаа зурах буюу дүрслэн бичих даалгавартай байсан. Би зурж байхдаа энэ зургийг гайхамшигтайг нь мэдэрч бусдаасаа ялгаатай болохыг нь ойлгосон. Тэдгээрийн зарим нь маш хурц өнгийг хэрэглэсэн байсан ба зарим нь хоорондоо холилдсон байлаа. Бид музейд очиж зураг сонирхсоны дараа бидэнд зургийн хичээл орсон. Бидний ажил бол жижигхэн охины барималыг хараад зурах даалгавар байлаа. Бид зурж байхдаа нэгэн арга барилыг сурсан бөгөөд энэ нь зургийн өнгө үзэмжид маш ихээр нөлөөлдөг болохыг би олж мэдсэн. Хүн болгон барималыг өөр өөр өнцгөөс нь харж байсан болохоор бүгд өөр өөр зураг зурцгаасан. Миний бодлоор энэ аялал бидэнд гайхалтай туршлага болсон бөгөөд хөгжилтэй байсан.

Бага Сургуулийн Эрхлэгч Jan Wiggins

Багш нарын талархалын өдрийн мэнд хүргэе

Бид нар ер нь багш наргүйгээр яах байсан бэ? Өнгөрсөн жилийн H1N1 үеэр сургууль хаагдах үед багш наргүйгээр ямар байхыг бид мэдэрсэн. Энэ бол маш хэцүү цаг хугацаа байсан бөгөөд бага ч гэсэн багшийн үнэ цэнийг ойлгуулж өгсөн юм. Багш нарын талархалын өдрийг Америкийн Нэгдсэн Улсад 5-р сарын эхний долоо хоногт тэмдэглэсээр ирсэн. ОУДС-ийн ЭББ багш нартаа талархал сэтгэлийн илэрхийлж энэ Баасан гаригт бяцхан хүлээн авалт хийх гэж байна. Та бүхэн хүүхдийнхээ багш нартай уулзахдаа “Талархал Илэрхийлэхээ” мартуузай.

Түүнчлэн ЭББ **5-р сарын 18-ны орой 7 цагт ОУДС-ийн номын санд хурал** зохион байгуулах гэж байна. Энэхүү хурлаар ирэх жилийн Намрын Баярын төлөвлөгөөг хэлэлцэнэ. Мөн хурлаар шинэ хичээлийн жилд ажиллах ЭББ-н гишүүдийг сонгох талаар ярилцана. Хэдийгээр та ЭББ-н ажилд тусалж амжаагүй байгаа ч энэ хуралд заавал ирж оролцоорой. ЭББ маш олон сайхан ажлуудыг манай сургууль дээр зохион байгуулдаг. ЭББ-с зохиож байгаа ажилд та оролцсоноор хүүхдийнхээ боловсрол болон сургуулийн амьдралд өөрсдийн хувь нэмрийг оруулж байгаагийн нэг илрэл юм.

БИЕИЙН ТАМИРЫН ТЭНХМЭЭС

Хятадын Qingdao хотноо болсон ACAMIS хөл бөмбөгийн тэмцээнд манай сургуулийн охид хөвгүүдийн баг амжилттай оролцоод ирлээ. Хөвгүүдийн багт: Derryn, Vasek, Jiri, Мишээл, Kristian, Mathias, Ha Ram, Пүрэвбат, Jun Woo, Хишигдорж; Охидын багт: Reeza, Rebekah, Цолмон, Намуун, Catriona, Madeline, Elise, Пүрэвсүрэн, Tiffany, Teresa нар тус тус тоглосон.

Багш David Ricketts, Sou Cheng Leong, Maaike Lohman нар хөл бөмбөгийн багийн дасгалжуулагчаар ажилласан. Манай охидын баг 2-р байранд орж мөнгөн медаль авч, хөвгүүдийн баг 4-р байранд шалгарсан. Derryn, Tiffany, Rebekah, Elise нар бүх оддын багт шалгарсан.

Тэмцээнд амжилттай оролцсон бүх сурагчиддаа болон багш дасгалжуулагч нарт баяр хүргэе!

Дугуйлангийн талаар:

Сурагчдын 4-р улирлын дугуйлангууд хичээллэж эхэлсэн. Дугуйланд хамрагсдын тоо эцэслэн гарч унааны зохицуулалт хийгдсэн байгаа. Цөөхөн тооны хүүхдүүд хичээллэж байгаа зарим дугуйлангуудын хувьд өөрчлөлт хийгдэж магадгүй. Өөрчлөлт хийсэн тохиолдолд бид эцэг эхчүүдэд тухай бүрт нь мэдээлэх болно.

Сургуулийн багууд хоорондын уралдаан тэмцээний дүн удахгүй гарах гэж байна. Багуудын ойролцоо онооны зөрүүтэй явж байна. Та бүхэн багуудын нийлбэр дүнг Мэдээний англи эх хувиас сонирхоно уу.

Биеийн Тамирын Тэнхмийн Эрхлэгч David Ricketts